



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 12 сарын 09 өдөр

Дугаар А/435

Мөрөн сум

Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга  
хэмжээний ажлын жагсаалт, төсөвт  
өртөг батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, Эрчим хүчний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, Агаарын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.3, 14 дүгээр зүйлийн 14.1, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдын Хурлын 2021 оны 05 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас “Засаг дарга” ерөнхий дансанд баталсан “Агаарын бохирдол бууруулах” арга хэмжээний хүрээнд хийгдэх ажлын жагсаалт, төсөвт өртгийн жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2. Батлагдсан арга хэмжээг Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулж ажиллахыг аймгийн Орон нутгийн өмчийн газар (Б.Должинсорогдог)-т үүрэг болгосугай.

3. Дээрх зардлыг “Засаг дарга данс” –ны “Агаарын бохирдол бууруулах” зардлаас гаргаж зарцуулахыг төсвийн ерөнхийлөн захирагчийн Ерөнхий нягтлан бодогчийн үүргийг түр орлон гүйцэтгэгч (Л.Батжаргал)-д зөвшөөрсүгэй.

4. Ухаалаг тоолуурыг суурилуулж, аюулгүй байдалд хяналт тавьж ажиллахыг “Хөвсгөл-Эрчим хүч” ХХК-ний гүйцэтгэх захирал (З.Бадрал)-д даалгасугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Б.Мөнгөн-Эрдэнэ)-т үүрэг болгосугай.

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН

Аймгийн Засаг даргын 2022 оны 12  
дугаар сарын 09 –ний өдрийн А/435  
дугаар захирамжийн хавсралт

АГААРЫН БОХИРДОЛ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ  
АЖЛЫН ЖАГСААЛТ ТӨСӨВТ ӨРТӨГ

Арга хэмжээ	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хөрөнгийн хэмжээ	Санхүүжих дүн 2022 он
Агаарын бохирдол бууруулах	2 тарифт ухаалаг тоолуур худалдан авах	40,000,000	40,000,000
	Агаарын бохирдлын эх үүсвэрийн улсын тооллого зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх	3,000,000	3,000,000
	Агаарын чанарыг сайжруулах хязгаарлалтын бүсэд орж байгаа айл өрх аж ахуй нэгжийн дунд хэлэлцүүлэг зохион байгуулах	2,359,100	2,359,100
Нийт дүн		45,359,100	45,359,100